



УВС АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Аймгийн Аудитын газраас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийсэн нийцлийн аудитын тайлан.



**Орон нутгийн хурлын сонгуулийн зарим зардлын
гүйцэтгэлийг зөрүүтэй тайлагнасан байна.**

Орон нутгийн Хурлын сонгуулийн зардлын гүйцэтгэл

2016 оны 11 сар

УБААГ-2016/12-НА

АГУУЛГА

<u>Тайлан бэлтгэсэн:</u> Дарга, тэргүүлэх аудитор Б.Авирмэд Аудитын менежер Ж.Энхжаргал 2016 оны 11 дүгээр сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70453317, 7045-3721, дугаарын утсаар харилцана уу. Хаяг: Увс аймгийн Аудитын газар Улаангом сум 3 баг аймгийн Засаг даргын тамгын газрын байр	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Бүлэг 1. Орон нутгийн хурлын сонгуулийн батлагдсан төсвөөс зориулалт бус зардал гаргасан байна. 1.1.Төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон байна. 1.2.Батлагдсан төсвөөс зориулалт бус зардал гаргасан байна. Дүгнэлт Зөвлөмж Бүлэг 2. Хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хэрэгжсэн байна. 2.1. Сонгуулийн зарим зардлын гүйцэтгэлийг зөрүүтэй тайлагнасан байна. 2.2. Хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьсан байна. Дүгнэлт Зөвлөмж Холбогдох байгууллагын санал Аудитын газраас өгөх тайлбар	
--	--	--

Товчилсон үгийн тайлал:

ҮАГ- Үндэсний Аудитын Газар
ТХШС-Төрийн хяналт, шалгалтын стандарт
АДБОУС-Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 заалт, аймгийн Аудитын газрын 2016 оны ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Орон нутгийн хурлын 2016 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотой төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүнг шалгаж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ.Үүнд:

- Орон нутгийн хурлын сонгуулийг зохион байгуулах хөрөнгийг холбогдох хууль журмын дагуу зарцуулсан эсэх
- Хөрөнгийн зарцуулалтад тавьж буй хяналт үр дүнтэй эсэх

Хамарсан хүрээ

Аудитад аймаг, сумын сонгуулийн хороод, Оюун өмч, Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газрыг хамрууллаа.

Арга зүй

ТХШС, АДБОУС 4000, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт зөвлөмж боловсрууллаа.

Энэхүү нийцлийн аудитыг явуулахад Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журмыг баримталж ажиллав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлт, зөвлөмжид дэмжлэг болохуйц нотлох зүйлс, холбогдох бусад материалыг ажлын баримтад хавсаргав.

Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль эрх зүйн актыг шалгуур болгон ашиглав.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Сонгуулийн тухай хууль
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль
- Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан тогтоол, журам

БҮЛЭГ 1. Орон нутгийн хурлын сонгуулийн батлагдсан төсвөөс зориулалт бус зардал гаргасан байна.

1.1. Төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон байна.

Орон нутгийн хурлын 2016 оны ээлжит сонгуулийг 93 хэсэгт зохион байгуулснаас 4 хэсгийн хороонд нөхөн сонгууль явагдсан байна.

Сонгуулийн Ерөнхий хорооны ажлын албаны 2016 оны 10 сарын 28-ны өдрийн 287 тоот албан бичгээр Увс аймгийн сонгуулийн хороонд Орон нутгийн хурлын 2016 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардалд 327.9 сая төгрөг хуваарилжээ.

Цагдаагийн Ерөнхий газрын Санхүү хангамжийн газраас цагдаагийн албан хаагчийн холбооны зардалд 570.0 мянга, шатахуун, техник хэрэгслийн зардалд 1800.0 мянга, хоолны зардалд 4575.0 мянга, нийт 6945.0 мянган төгрөг хуваарилсан байна.

Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2016 оны А/131 тоот тушаалаар Увс аймагт сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, цахим хуудаст байрлуулах сонгогчдыг бүртгэх, тэднийг таньж оруулах болон санал авах техник хэрэгсэл, сэлбэг, программ хангамж, тусгай тэмдэглэл хийх хэрэгсэл, тэдгээрийг худалдан авах, түрээслэх, ашиглах, хадгалах, хамгаалах, засвар үйлчилгээг хийх, хэвлэх, тээвэрлэж хүргүүлэх, татан авах болон албан хаагчийн сургалт зохион байгуулах, томилолт, мөнгөн урамшуулал, бичиг хэрэг, тээвэр шатахуун, төлбөр хураамж, хоолны зардалд 43.9 сая төгрөгийг баталж хуваарилсан байна.

1.2. Батлагдсан төсвөөс зориулалт бус зардал гаргасан байна.

Орон нутгийн 2016 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах зардалд Увс аймгийн Сонгуулийн хороонд улсын төсвөөс 327.9 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Уг эх үүсвэрийг Сонгуулийн Ерөнхий хорооны 2016 он 04 тоот тогтоолын 1-р хавсралтаар баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 2.3 дахь заалтыг үндэслэн сумдын Сонгуулийн хороонд хуваарилан зарцуулжээ. Аймгийн Сонгуулийн хороонд хуваарилагдсан эх үүсвэрийн 90.1 хувь буюу 297.8 сая төгрөгийг орон нутгийн хурлын ээлжит сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулагдахад зарцуулсан байна. Дээрх журмын 3.3 дахь заалтын дагуу аймгийн Сонгуулийн хорооны сонгуулийн зардлын үлдэгдэл 29.3 сая, сумдын Сонгуулийн хороо сонгуулийн зардлын үлдэгдэл 0.8 сая, нийт 30.1 сая төгрөгийг Сонгуулийн Ерөнхий хорооны дансанд эргүүлэн төвлөрүүлсэн байна. Аймгийн Сонгуулийн хороонд хуваарилагдсан төсвийг Сонгуулийн Ерөнхий хорооны Ажлын албанаас өгсөн чиглэлийн дагуу сонгуулийн зардлын нэгтгэсэн тайлангийн маягтаар дараах байдалтай тайлагнасан байна. Үүнд:

/ төгрөгөөр/

д/д	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл		Үлдэгдэл
			Сумд	Аймгийн сонгуулийн хороо	
1	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	350 000		350 000	-
2	Төрөл бүрийн үнэмлэх хэвлүүлэх	8 370 100		8 370 100	-
3	Сургалтын зардал	13 470 000		13 470 000	-
4	Бичиг хэргийн зардал	11 740 000	10 290 000	1 167 700	282 300
5	Шуудан холбооны зардал	11 740 000	10 290 000	720 000	730 000
6	Унааны зардал	38 875 800	14 406 750	2 815 111	21 653 939
7	Хууль, тогтоомж сурталчлах зардал	8 000 000	2 850 900	2 500 000	2 650 000
8	Санал авах байр бэлтгэх зардал	18 600 000	18 600 000		
9	Мэдээлэл Технологийн багийн мэдээ дамжуулах зардал	600 000		320 000	280 000
10	Томилолтын зардал	8 759 600		7 133 650	1 625 950
11	Саналын хуудас авах зардал	5 794 000		4 973 380	820 620
12	ICP машиныг хүлээн авах, хүлээлгэн өгөх	14 757 200		14 406 920	350 280
13	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх	4 657 000	4 632 000		25 000
14	Болзошгүй зардал	3 000 000	1 711 200		1 288 800
15	Сурталчилгааны материал хүргэх зардал	2 050 000		1 640 000	410 000
16	Сонгуулийн байгууллагын ажилтан сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал хоолны зардал	146 035 900	140 953 600	5 082 300	
17	Мэдээлэл технологийн багийн гишүүн, даамал сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал хоолны зардал	31 092 800		31 092 800	-
	Дүн	327 892 400	203 734 450	94 041 061	30 116 889

Аудитын явцад зардлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулахад дараах зарим зардлын гүйцэтгэлийг зөрүүтэй тайлагнасан байсныг залрууллаа. Үүнд:

Д/д	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл		Үлдэгдэл
			Сумд	Аймгийн сонгуулийн хороо	
1	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	350 000		350 000	-
2	Төрөл бүрийн үнэмлэх хэвлүүлэх	8 370 100		8 315 400	54 700
3	Сургалтын зардал	13 470 000		13 428 156	41 844
4	Бичиг хэргийн зардал	11 740 000	10 253 155	1 167 700	319 145
5	Шуудан холбооны зардал	11 740 000	10 290 000	720 000	730 000
6	Унааны зардал	38 875 800	17 253 750	1 616 790	20 005 260
7	Хууль, тогтоомж сурталчлах зардал	8 000 000	2 817 900	2 500 000	2 682 100
8	Санал авах байр бэлтгэх зардал	18 600 000	18 210 400		389 600
9	Мэдээлэл Технологийн багийн мэдээ дамжуулах зардал	600 000		320 000	280 000
10	Томилолтын зардал	8 759 600		7 179 050	1 580 550
11	Саналын хуудас авах зардал	5 794 000		4 519 440	1 274 560
12	ICP машиныг хүлээн авах, хүлээлгэн өгөх	14 757 200		14 407 360	349 840
13	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх	4 657 000	4 236 500		420 500
14	Болзошгүй зардал	3 000 000	1 421 210		1 578 790
15	Сурталчилгааны материал хүргэх зардал	2 050 000		1 640 000	410 000
16	Сонгуулийн байгууллагын ажилтан сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал хоолны зардал	146 035 900	141 008 800	5 027 100	-
17	Мэдээлэл технологийн багийн гишүүн, даамал сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал хоолны зардал	31 092 800		31 092 800	-
	Дүн	327 892 400	205 491 715	92 283 796	30 116 889

Түүнчлэн Сонгуулийн хорооны 2016 оны 621 дугаар албан бичгийн хавсралтын 5-д “Сурталчилгааны материал хүргэх зардал: Сурталчилгааны материалыг Сонгуулийн Ерөнхий Хорооноос авах, сонгогчдод сурталчилгааны материал түгээхэд энэ зардлыг ашиглана. 1 суманд дундажаар 200 км х 500₮ гэж тооцсон” гэснийг зөрчин аймгийн Сонгуулийн хороо сурталчилгааны материалыг сумдад хүргэж өгөх бензины зардалд зарцуулж зориулалт бус зардал гаргасан байна.

Завхан, Хяргас, Сагил, Тариалан сумдад нөхөн сонгууль явагдаж эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардалд 75.0 мянга, томилолтын зардалд 116.0 мянга, унааны зардалд 599.3, хоолны зардалд 300.0 мянга, нийт 1090.3 мянган төгрөг зарцуулсан байна.

Увс аймгийн Цагдаагийн газарт хуваарилагдсан зардлыг Орон нутгийн хурлын сонгуулийн санал авах байрны хамгаалтанд ажилласан нийт 109 алба хаагчдын хоол, шуудан холбоо, унааны зардалд зарцуулсан байна. Увс аймгийн хэмжээнд 19 сумын 93 хэсгийн хорооны санал авах байрны хамгаалалтанд 93, аймгийн сонгуулийн хорооны хамгаалалтанд ээлжээр 6, нийт 99 алба хаагчдыг томилон, 10 алба хаагчдыг нөөцөөр ажиллуулсан байна. Нөөцөөр ажилласан алба хаагчид хоолны зардалд 243.0 мянган төгрөгийг зарцуулжээ. Цагдаагийн Ерөнхий газрын Санхүү хангамжийн газраас хуваарилсан зардлаас хоолны зардалд 4575.0 мянга, шуудан холбооны зардалд 570.0 мянга, шатахууны зардал 1800.0 мянга, нийт 6945.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2016 оны А/131 дугаар тушаалаар баталж Орон нутгийн хурлын ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой Увс аймагт хуваарилсан 43.9 сая төгрөгийн эх үүсвэрийг зориулалтын дагуу зарцуулсан байна. Төлбөр хураамжийн зардлын үлдэгдэл 470.9 мянган төгрөгийг дээд шатны байгууллагын дансанд төвлөрүүлэхийг зөвлөмж болголоо. Хуваарилагдсан зардлын төсөв, гүйцэтгэл дараах байдалтай байна. Үүнд:

№	Зардлын зүйл анги	/төгрөгөөр/ Мөнгөн дүн	
		төсөв	Гүйцэтгэл
1	Урамшуулалт цалин	22261140	22261140
2	сургалтын зардал	8460000	8460000
3	тээвэр шатахуун	5654000	5654000
4	Томилолтын зардал	639000	639000
5	Бичиг хэрэг	2999117	2999117
6	Хоолны зардал	2574000	2574000
7	БҮТЭЗ	850000	850000
8	Төлбөр хураамж	470883	
	Нийт дүн	43908140	43437257

Дүгнэлт :

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Увс аймгийн хэмжээнд Орон нутгийн хурлын 2016 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах зардалд нийт 378.7 сая төгрөгийн эх үүсвэр хуваарилагдсныг зориулалтын дагуу зарцуулж 30.6 сая төгрөгийн хэмнэжээ.
2. Увс аймгийн Оюуны өмч, Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсан сонгуулийн зардлын үлдэгдэл 470.9 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй байна.

Зөвлөмж:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Оюуны өмч, Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Р.Отгонбаяр танаа

1. Увс аймгийн Оюуны өмч, Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсан сонгуулийн зардлын үлдэгдэл 470.9 мянган төгрөгийг төвлөрүүлэх.

БҮЛЭГ. 2 Хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хэрэгжсэн байна.**2.1. Сонгуулийн зарим зардлын гүйцэтгэлийг зөрүүтэй тайлагнасан байна.**

Сонгуулийн Ерөнхий хорооны 2016 он 04 тоот тогтоолын 1-р хавсралтаар “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 4-д “Сонгуулийн зардлын бүртгэл хөтлөх, гүйцэтгэлийн тайлан гаргах”-тай холбоотой заалтуудыг аймаг, сумдын сонгуулийн хороо хэрэгжүүлж ажилласан байна. Харин аймгийн Сонгуулийн хороо сонгуулийн зардлын төсвийн гүйцэтгэлийг тайлагнахдаа зарим зардлыг зөрүүтэй тайлагнасан байсныг зөвлөмж өгч залрууллаа.

2.2. Хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьсан байна.

Дээрх журмын 3 дугаар зүйлийн 3.1, 3.4 дах заалтуудын дагуу аймаг, сумдын сонгуулийн хороо Төрийн санд зардлын данс нээлгэн хуваарилсан төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу захиран зарцуулсан байна.

Мөн журмын 3.2-д “Сонгуулийн хороод нь хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай бол дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ” гэж заасан байна.

Дээрх заалтыг үндэслэн Увс аймгийн Сонгуулийн хороо албан бичгээр Сонгуулийн ерөнхий хороонд хандан унааны зардлаас төрөл бүрийн үнэмлэх хэвлэх, эрчим хүчний эх үүсвэр, хоолны зардалд 7499.2 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулахыг шийдвэрлэж өгөх хүсэлт гаргасныг шийдвэрлэсэн байна.

Түүнчлэн 4 сум сонгуулийн зардлаас 14 нэр төрлийн 442.0 мянган төгрөгийн аж ахуй, хангамжийн материал худалдан авсан ч данс бүртгэлд тусгаагүй байсныг холбогдох байгууллагуудад хандаж бүртгэлд тусгуулах зөвлөмж өглөө.

Данс бүртгэлд тусгаагүй бараа материалын жагсаалт

№	Сумын нэр	Материалын нэр	Хэмжих	Тоо	Нэг бүрийн үнэ	нийт үнэ
1	Давст	Үдээсний машин	ш	1	10000	10000
2		Үдээсний машин	ш	1	65000	65000
3		Гар чийдэн	ш	1	20000	20000
4		Халаалтын тен	ш	1	45000	45000
5	Зүүнхангай	Гар чийдэн	ш	3	12000	36000
6		Уртасгагч	ш	5	12000	60000
7		Гэрлийн утас	м	20	2500	50000
8	Түргэн	Үдээсний машин	ш	2	5000	10000
9		тооны машин	ш	1	6000	6000
10		тооны машин	ш	1	10500	10500
11	Цагаанхайрхан	Уртасгагч	ш	2	16000	32000
12		Гэрлийн утас	м	20	3500	70000
13		Сурталчилгааны самбар	ш	1	20000	20000
14		Үдээсний машин	ш	1	7500	7500
		ДҮН		60		442000

Дүгнэлт :

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. 4 сум сонгуулийн зардлаас 14 нэр төрлийн 442.8 мянган төгрөгийн аж ахуй, хангамжийн материал худалдан авсан ч данс бүртгэлд тусгаагүй байна.

Зөвлөмж:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.Үүнд:

Сонгуулийн хорооны дарга Б.Эрдэнэсүрэн танаа

1. Сонгуулийн зардлаас бараа материал бэлтгэсэн ч данс бүртгэлд тусгаагүй 4 суманд албан тоот хүргүүлэх

Холбогдох байгууллагын санал


**УВС АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО**
213400, Улаангом, Увс аймаг
Утас/Факс: 7045-3923

2016. 11.10 № 15

танай _____ -ны № _____ -т

Аймгийн Аудитын Газарт

Орон нутгийн хурлын сонгуулийн тайлангийн
нийцлийн аудитын тайлантай танилцлаа.
Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

ДАРГА  Б. ЭРДЭНЭСҮРЭН



УВС АЙМАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

85165 Увс аймаг, Улаангом сум, 3 дугаар баг,
Улсын бүртгэлийн хэлтсийн байр,
Утас/Факс: (976) 7045 2244, E-mail: uvs@burtgel.gov.mn

2016.11.10 № 1/995

танай _____-ны № _____-т

УВС АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Орон нутгийн хурлын сонгуулийн зардлын гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа. Аудитын дүнд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн зардлын үлдэгдлийг төвлөрүүлнэ.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Р.ОТГОНБАЯР



**Холбогдох байгууллагын ирүүлсэн
саналд өгөх тайлбар**

Тайлангийн төсөлтэй танилцаж Сонгуулийн хорооны 2016 оны 11-р сарын 10-ны өдрийн 15, Оюуны өмч, Улсын бүртгэлийн хэлтсийн 2016 оны 11-р сарын 10-ны өдрийн 1/995 албан тоотоор ирсэн хариуг үндэслэн тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

ТАЙЛАН ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.АВИРМЭД

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Ж.ЭНХЖАРГАЛ